



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

┌
Тарваган тахал өвчнөөс урьдчилан
сэргийлэх ажлын бэлэн байдлыг хангах тухай
└


Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Заавар батлах тухай” А/160 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, 2018 оны “Халдварт өвчний тохиолдлыг тандах журам батлах тухай” А/527 дугаар тушаал, НЭМГ-ын даргын А/86 тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 тоот албан даалгаварыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Харьяа ӨЭМТ-ийн дарга, тасгийн эрхлэгч нарт даалгах нь:
 - 1.1 Голомтонд дайчлан ажиллуулах мэргэжилтнүүдийн судалгааг гарган томилж, үүрэгжүүлэх,
 - 1.2 Эмнэлгийн тусгаарлах өрөөний нэн шаардлагатай эм, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгслийн жагсаалт, тоо хэмжээг гаргаж, бэлэн байдлыг хангах,
 - 1.3 2019 оны 07-р сарын 01-ээс 07-р сарын 10-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулагдах тарваган тахал өвчний эсрэг дархлаажуулалтын 10 хоногийн аянд эрсдэлт бүлгийн иргэдийг хамруулах,
 - 1.4 Тарваган тахлын сэжигтэй өвчтөн ирсэн үед тусгаарлах өрөөнд тусгаарлан, нарийн мэргэжлийн эмч нар оношийг тогтоож, өвчтөнийг эмнэлэг дамжуулан явуулахгүй байх,
 - 1.5 Тарваган тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвд 30 минутаас 2 цагийн дотор яаралтай мэдээлж, эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг хийж, эрсдлийн зэргийг тогтоон, гарааны арга хэмжээг авч, голомтын хариу арга хэмжээг үйл явдлын тэргүүлэгч байгууллагатай хамтран зохион байгуулах,
 - 1.6 Хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг оношлох, мэдээлэх, өвчтөнөөс лабораторын сорьц авах, савлах, тээвэрлэх, тархвар судлал, тандалтын хариу арга хэмжээ авах талаар эмч, мэргэжилтнүүдийг сургах,
 - 1.7 Нийт хүн ам болон эрсдэлт бүлгийн хүн амд тарваган тахал өвчнөөс сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг идэвхижүүлэн, зохион байгуулах,

30170 70 0500

- 1.8 Хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явцын талаарх мэдээллийг баримтжуулан тус төвийн тархвар судлаач /Б.Цэндсүрэн/-д tsendsurenbb@gmail.com цахим хаягаар сар бүрийн 20-ны өдрийн дотор илгээх,
2. Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг тархвар судлаач /Б.Цэндсүрэн/, иргэдэд чиглэсэн зөвлөмж, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг сургалт хариуцсан мэргэжилтэн /Ч.Гүнчинхорлоо/ нарт үүрэг болгосугай,
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

ДАРГА



Э. БОДЬЦЭЦЭГ